



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/04/СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2021 он</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням Утас: 260949 Цахим хаяг: sambuunyamyа@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn Аудитор: Э.Бүгүнүтэй Утас: 260512 Цахим хаяг: bugunuteie@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	4
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал	7
3.4 Материаллаг байдал.....	8
3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	9
3.8 Аудитын гол асуудал.....	9
3.9 Шилэн дансны мэдээлэл	9
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10
4. Аудитын илрүүлэлт.....	11
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	11
Аудитын зөвлөмж	11
4. Менежментийн захидал.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН
ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН
КОМИССЫН ДАРГА С.ОДОНТУЯА
ТАНАА

2021.04.26 № 1313

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,064.0	19,572.0
35	БАРАА МАТЕРИАЛ	11,064.0	19,572.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	52,999.8	42,059.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	52,999.8	42,059.8
39200	Биет хөрөнгө	42,481.0	35,802.7
39300	Биет бус хөрөнгө	10,518.8	6,257.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	64,063.8	61,631.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	64,063.8	61,631.8
51	Засгийн газрын хувь оролцоо	64,063.8	61,631.8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	50,239.4	50,239.4
51200	Хуримтлагдсан үр дүн	12,992.6	10,560.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	831.8	831.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	64,063.8	61,631.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,553,436.7	54,374,496.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,553,436.7	54,374,496.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,552,953.8	54,401,540.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,552,953.8	54,401,540.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	458,342.9	447,829.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	178,149.6	193,702.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,125.1	26,578.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,603.5	30,990.0
2104	Хангамж, бараа материалын зардал	23,948.3	27,738.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,210.8	1,087.8
2107	Томилот, зочны зардал	14,325.0	7,476.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	148,247.6	131,012.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,732.9	29,244.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,094,611.0	53,953,710.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	482.9	(27,043.7)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	288.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	482.9	(27,332.4)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,553,436.7	54,374,496.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,553,436.7	54,374,496.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,535,608.6	54,367,961.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,535,608.6	54,367,961.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	440,997.6	414,251.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,913.5	181,268.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,984.8	24,639.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,603.5	30,990.0
2104	Хангамж, бараа материалын зардал	22,168.0	31,932.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,210.8	1,087.8
2107	Томилолт, зочны зардал	14,325.0	7,476.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	156,178.0	124,799.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,614.0	12,058.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,094,611.0	53,953,710.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	17,828.1	6,534.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	17,828.1	6,534.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,828.1	6,534.6
2200	Дотоод эх үүсвэрээр	17,828.1	6,534.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-17,828.1	-6,534.6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

		/мянган төгрөгөөр/		
Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч	
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	63,580.9	-	63,580.9	
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	63,580.9	-	63,580.9	
Тайлант үеийн үр дүн	482.9	-	482.9	
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,063.8	-	64,063.8	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	24,900.4		24,900.4	
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	88,964.2	-	88,964.2	
Тайлант үеийн үр дүн	(27,332.4)	-	(27,332.4)	
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	61,631.8	-	61,631.8	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

					/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	54,374,496,400.00	54,357,940,115.07	16,556,284.93	99.97	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	54,374,496,400.00	54,357,940,115.07	16,556,284.93	99.97	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422,267,800.00	420,786,115.07	1,481,684.93	99.65	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,513,300.00	181,268,466.17	1,244,833.83	99.32	
210101	Үндсэн цалин	116,511,600.00	130,887,831.04	(14,376,231.04)	112.34	
210102	Нэмэгдэл	51,719,300.00	33,902,947.20	17,816,352.80	65.55	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,282,400.00	16,477,687.93	(2,195,287.93)	115.37	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,639,500.00	24,639,500.00	-	100.00	
210201	Тэтгэврийн даатгал	17,338,800.00	17,338,800.00	-	100.00	
210202	Тэтгэмжийн даатгал	1,825,100.00	1,825,100.00	-	100.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,460,200.00	1,460,200.00	-	100.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	365,100.00	365,100.00	-	100.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	3,650,300.00	3,650,300.00	-	100.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,990,300.00	30,990,000.00	300.00	100.00	
210304	Байрны түрээс	30,990,300.00	30,990,000.00	300.00	100.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	31,933,700.00	31,932,079.17	1,620.83	99.99	
210401	Бичиг хэрэг	3,270,700.00	3,270,278.00	422.00	99.99	
210402	Тээвэр, шатахуун	6,762,000.00	6,762,000.00	-	100.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,228,000.00	5,126,801.17	101,198.83	98.06	
210404	Ном, хэвлэл	12,200,000.00	12,300,000.00	(100,000.00)	100.82	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,473,000.00	4,473,000.00	-	100.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,630,000.00	7,622,400.00	7,600.00	99.90	
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,210,400.00	5,125,000.00	1,085,400.00	82.52	
210602	Тавилга	1,419,600.00	1,419,600.00	-	100.00	
210604	Урсгал засвар	-	1,077,800.00	(1,077,800.00)		
2107	Томиллолт, зочны зардал	7,477,800.00	7,476,100.00	1,700.00	99.98	
210702	Дотоод албан томилолт	7,477,800.00	7,476,100.00	1,700.00	99.98	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	125,011,700.00	124,799,319.73	212,380.27	99.83	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	113,477,700.00	113,265,319.73	212,380.27	99.81	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,534,000.00	11,534,000.00	-	100.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,071,500.00	12,058,250.00	13,250.00	99.89	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,148,100.00	2,148,100.00	-	100.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,923,400.00	9,910,150.00	13,250.00	99.87	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,952,228,600.00	53,937,154,000.00	15,074,600.00	99.97	
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,952,228,600.00	53,937,154,000.00	15,074,600.00	99.97	
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	-	100.00	

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,908,430,000.00	53,893,355,400.00	15,074,600.00	99.97
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,354,800.00	39,354,800.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,443,800.00	2,443,800.00	-	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	54,374,496,400.00	54,357,940,115.07	16,556,284.93	99.97
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	54,374,496,400.00	54,357,940,115.07	16,556,284.93	99.97
310001	Улсын төсвөөс санхүүжих	54,374,496,400.00	54,357,940,115.07	16,556,284.93	99.97
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	23	23	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	11	11	-	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	11	11	-	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7	7	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	4	-	100.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Энхжин, аудитор Э.Бүгүнүтэй нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 223 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын дүрэмд тус байгууллагын эрхэм зорилгыг “Улсын комиссын зорилт нь төрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн, нам, төрийн бодлого, шийдвэрт шүүмжлэлтэй хандсан гэх шалтгаанаар хилсээр шийтгүүлсэн, нам, захиргааны байгууллагаас хилсээр арга хэмжээ авагдсан иргэдийн хэргийг шалгаж, шийдвэрлүүлэх, хэлмэгдсэн иргэнд хууль тогтоомжийн дагуу тэтгэмж, тусламж, нөхөх олговор олгуулах, хэлмэгдэгсдийн нэр төрийг сэргээн сурталчлахад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг татан оролцуулах ажлыг зохион байгуулахад оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс нь 2020 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,552.9 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 111.1 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.4 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	11.0	19.5	8.5
Үндсэн хөрөнгө	53.0	42.0	-11.0
Нийт хөрөнгө	64.0	61.6	-2.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	64.0	61.6	-2.4

Бараа материалын дансны үлдэгдэл 19.5 сая төгрөг болж 8.5 сая төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материалын үлдэгдэл өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 42.0 сая төгрөг болж 11.0 сая төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны А-1/1127 дугаар тогтоолын дагуу 11.0 сая төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 53.3 хувь буюу 48,846.0 сая төгрөгөөр, нийт зардал өмнөх оноос 19.1 хувь буюу 48,848.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 54,512.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2020 оны төсвийн хязгаарыг 54,473.4 сая төгрөгөөр баталсан ба төсвийн ерөнхийлөн захирагч 54,512.8 сая төгрөгийн төсвийн төсөл боловсруулж хүргүүлснийг 138.3 сая төгрөгөөр бууруулж 54,374.5 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулсан төсвийн төслийг төсвийн хязгаарт багтаах, 2020 оны тэвчиж болох зардлыг танах бодлого чиглэлийн дагуу бууруулсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрт зориулан 54,374.5 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 54,374.5 сая төгрөг олгожээ.

Төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 54,357.9 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1.2 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллыг 15.1 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 16.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т “Нэхэмжлэл гаргах эрх нь энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө цагаатгагдсан иргэдийн хувьд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор, энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш цагаатгагдсан иргэдийн хувьд цагаатгасан шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 жилийн хугацаанд байна” гэж зааснаар цагаатгуулах тухай өргөдөл, гомдол болон нөхөх олговрын нэхэмжлэл гаргах хугацаа 2020 оны 12 дугаар сарын 31-нд дуусгавар болсон байна.

3.8 Аудитын гол асуудал

Улсын төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Улсын комиссын дүрэм болон бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, нэр төрийг нь сэргээх, тэдэнд нөхөх олговор олгох ажлын хүрээнд Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 онд хэрэгжүүлэх төсөвт, хөтөлбөрийн хүрэх үр дүнд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 13.2.1, 13.2.2 дахь заалтыг үндэслэн 963 иргэнд 53,908.4 сая төгрөгийн нөхөх олговор олгохоор батлагдсанаас 931 иргэнд 53,890.5 сая төгрөг олгосон байна.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд төсвийн захирагч мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 195 мэдээллээс 135 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 38 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 21 мэдээллийг мэдээлээгүй мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 11,885.3 сая төгрөгийн 51 ажил гүйлгээг байршуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 82.1 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 37.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 44.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	37.5	1	37.5	100.0
Зөвлөмж	3	44.6	3	44.6	100.0
Нийт дүн	4	82.1	4	82.1	100.0

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,906.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11,904.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 2.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 11,904.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант онд 4 байгууллагатай нийт 19.5 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэх шууд гэрээ байгуулсан боловч гэрээний хэрэгжилт, үүргийн биелэлтийг дүгнээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Шилэн дансны цахим хуудсанд Тайлант хугацаанд оруулбал зохих 195 мэдээллээс 38 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 21 мэдээллийг байршуулаагүй, мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 11,885.3 сая төгрөгийн 51 ажил гүйлгээг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5 -д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.10-д "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 2.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлыг зориулалт бусаар зарцуулсантай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлаас хэлмэгдэгсдийн өдрийн арга хэмжээнд 2.1 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу эдийн засгийн ангиллын дагуу, үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Хавсралт

Огноо: 2021.04.25	Аудитын нэр: Цагтаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/4/СТА-ТЕ3
Шалгагдсан байгууллагын нэр: Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс	Сая төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд 4 байгууллагатай нийт 19.5 сая төгрөгийн ажил гүйцэтгэх шууд гэрээ байгуулсан боловч гэрээний хэрэгжилт, үүргийн биелэлтийг дүгнээгүй.	19.5	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Д.Ууганбаатар, Х.Хажидмаа
2	Шилэн дансны цахим хуудсанд Тайлант хугацаанд оруулбал зохих 195 мэдээллээс 38 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 21 мэдээллийг байршуулаагүй, мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 11,885.3 сая төгрөгийн 51 ажил гүйлгээг байршуулаагүй байна.	11,885.3	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Д.Ууганбаатар, Х.Хажидмаа
3	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлаас хэлмэгдэгсдийн өдрийн арга хэмжээнд 2.1 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан.	2.1	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Д.Ууганбаатар, Х.Хажидмаа
ДҮН		11,906.9			